



Шилийн богд, Ганга нуурын аялал

Ерөнхий мэдээлэл

Улс: Монгол

Чиглэл: Зүүн аймаг

Хугацаа: 5 шөнө, 4 өдөр

Эхлэх өдөр: 2020-09-25 - 2020-06-29

Код: ш62020

Үзэх зүйлс

- Дотоодын аяллыг 18 жилийн турш зохион байгуулсан мэргэжлийн баг хамт олон таны аяллыг зохион байгуулна
- Энгийн биш тусгай сонирхлын аялал тул үйлчилгээ бүр нь онцлог, сонирхол татсан байдаг
- Аяллын зориулалттай, тав тухтай аяллын унаа үйлчилнэ
- 5-с дээш жилийн туршлагатай, мэргэшсэн аяллын жолооч аюулгүй байдлыг ханган ажиллана
- 5-с дээш жилийн туршлагатай, мэргэжлийн аяллын хөтөч-тайлбарлагч үйлчилнэ
- Монголын нэрт яруу найрагчтай хамт аялна.

Үнэ

Сонголт 1 - Нийт үнэ: **660,000₮**

Аяллын хөтөлбөр

Өдөр 1. Улаанбаатар - Баруун Урт - 580км

Өглөө **07:00** цагт цуглан автобусаар Сүхбаатар аймгийн төв Баруун Урт хот руу явна. Замдаа хуучнаар Өндөрхаан буюу Хэнтий аймгийн төв Чингис хотод түр саатаж өдрийн хоол идээд цааш явна. Ойролцоогоор оройны **19:00** цагийн үед **Баруун-Урт** хотод ирж зочид буудалд байрлан, оройн хоол идсэний дараа амарна.

Өдөр 2. Сүхбаатар /Шилийн богд/ - 230км

Өглөөний цай уусны дараа зочид буудлын өрөөгөө хүлээлгэж өгнө. Үүний дараа 170 км орчим автобусаар яваад Дарьгангын алдарт **Талын агуй** руу орж дурсгалын зургаа татуулна. Өдрийн хоол Дорнодын өргөн уудам талд “Туждаа Хамт Явах Юмсан” дууг сонсонгоо иднэ. Үдээс хойш Шилийн богд уулын хормойд байрлах бааз дээр байрлан оройн хоолонд хорхог иднэ.

Өдөр 3. Сүхбаатар /Ганга нуур/ - 60км

Өглөөний цай уусны дараа Шилийн сайн эрсийн **Шилийн богд ууланд** гарч хийморио сэргээнэ. [Дарьганга сумаас](#) зүүн урагш 60 км-т далайн түвшнээс дээш 1778 метрт оршдог Дарьгангын энэ өндөрлөг тэгш газарт 200 орчим унтарсан галт уул байдгийн хамгийн өндөр нь Шилийн богд уул юм. Өдрийн хоол жуулчны бааз дээрээ идсэний дараа Дарьганга сумын **Алтан овоо, Ганга нуур, Молцог элс**, хөшөө дурсгал, бичигт хад, хүн чулуун хөшөөг үзэн аялна. Орой “Гангар хун” жуулчны бааз дээр ирж оройн хоолоо идээд амарна.

Өдөр 4. Сүхбаатар /Баруун урт/ - 50км

Өглөөний цайны дараа Баруун урт хот руу явна. Өдрийн хоол замд Алтан овооны хажууд иднэ. Энэ өдөр **чөлөөт хөтөлбөртэй** ба Баруун-Урт хотын зочид буудалд байрлан амарна. Оройн хоол зочид буудалд иднэ.

Өдөр 5. Баруун Урт - Улаанбаатар - 580 км

Өглөөний цайны дараа зочид буудлын өрөөгөө хүлээлгэн өгөөд Улаанбаатар хот руу буцна. Чингис хотод өдрийн хоол иднэ. Улаанбаатар хотод ирснээр манай аялал өндөрлөнө.

Аялалын зардалд багтсан

- Тээврийн зардал
- Дотоодын аялагчдын даатгал
- Аяллын хөтөлбөрт заасан үзвэр, үйлчилгээний төлбөр
- Хилийн зурваст нэвтрэх зөвшөөрөл
- ТХГ нутгийн хураамж
- Аяллын хөтөлбөрт заасан хоол
- Хөтөч тайлбарлагч

Аялалын зардалд багтаагүй

- “Аяллын зардалд багтсан”-аас бусад зарда
- Хувь хүний хэрэглээний зардал